



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар А/82

Бөхт

Засаг даргын нөөцөөс хөрөнгө зарцуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5, 2.1.6 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1. Засаг даргын Тамгын газарт 20 жил ажиллаж байгаад гавьяаны амралтандаа гарсан жолооч Ш.Болд нь хүнд өвчний улмаас таалал төгссөн тул ар гэрт нь 300,000 (гурван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, санхүүгийн гүйлгээ хийхийг нягтлан бодогч (Б.Өлзийням)-д зөвшөөрсүгэй.

3. Холбогдох санхүүгийн баримт бүрдүүлж ажиллахыг нярав (Т.Батбилэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ